# ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 05 дугаар сарын 20 — Мандалговь хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 1: Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | |
| **1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2-т заасан Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.** | | | | | | | |
| 1.1.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | Лавлагаа шатлалын ЭМБ, Тэнхимээр 5 удаа, Анхан шатны ЭМБ-д цахимаар-4, тэнхимээр-5 удаа зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулсан. | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Гэрээт 39 эрүүл мэндийн байгууллагуудтай "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ"-г байгуулан 14 төрлийн тусламж үйлчилгээнд нэхэмжлэлийн хяналт хийж сар бүр хяналтаар илэрсэн зөрчлийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад албан бичгээр тайлбар мэдээлэл хүргүүлэн лавлагаа шатлалын 3 эрүүл мэндийн байгууллагад тэнхимээр 2, анхан шатны эрүүл мэндийн байгуулагуудад цахимаар 3, цаасаар-2, тэнхимээр 2 удаа сургалт мэдээлэл өгч ажилласанаар зөрчлийн тоо өмнөх мөн үеийн үзүүлэлтээс 73,4 хувиар буурч, мөнгөн дүн 86,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br> | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2 | Эрүүл мэндийн даатгалын 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | - | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэл ирээгүй байгаа бөгөөд сар бүр гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн мэдээллийг аймгийн засаг дарга болон Нийгмийн бодлогын хэлтэс, гэрээт эрүүл мэндийн байгуулагуудын удирдлагуудад хүргүүлж ажилладаг. | 100 |
| 1.1.3 | "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 06, 10 дугаар тогтоолыг гэрээт 20 эрүүл мэндийн байгууллагад танилцуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. | Журмыг хэрэгжүүлсэн байна. | 2025 онд батлагдсан ЭМДҮЗ-ийн 03,04,10 дугаар тогтоолыг гэрээ бүхий лавлагаа шатлалын 3, анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд Бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан тогтоолын шинэчлэлийн 8 удаагийн цахим сургалтад гэрээт байгуулагуудыг бүрэн хамруулсан бөгөөд мөн хэлтсээс шинэчилсэн тогтоолын мэдээллийг Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулж оролцогчдын сонирхсон асуултад хариуллаа.<br>Тогтоолын шинэчлэлтэй холбоотой гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас ирсэн асуултад хариулж өгч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна. | 90 |
| 1.1.4 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 20 анхан шатны ЭМБ-д хүргэн ажиллалаа. | Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна. | 2025 онд батлагдсан ЭМДҮЗ-ийн 03,04, 10 тогтоолыг гэрээ бүхий анхан шатны 16, лавлагаа шатлалын 3 эрүүл мэндийн байгууллагуудад т хүргүүлэн тэнхимээр 3, цахимаар 2 удаагийн сургалт мэдээлэл өгч мэргэжил арга зүйгээр хангаж сар бүр хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийж ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | - | - Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо | ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2024 онд 1321 иргэн хамрагдаж 211,4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | Одоогийн байдлаар нэгдсэн эмнэлэг нь “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг”-ээр гэрээлэн ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 03 сарын байдлаар 677 иргэн даатгуулагчийг эрт илрүүлэг үзлэгт хамруулан цахим хяналтаар 950000 төгрөг хасагдан 120,270,000.00 төгрөгийн санхүүжилт олгосон байна. | 100 |
| 1.1.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | - | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | 3 удаа дүн шинжилгээ хийгдэж 3 санал хүргүүлсэн. | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд сар бүр нэхэмжлэлийн хяналтыг хийж гүйцэтгэн нэхэмжлэлийн мөнгөн дүн, хяналтаар илэрч буй зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөөс гадна Бодлого төлөвлөлтийн газрын холбогдох мэргэжилтэнд улаан бурхан өвчний нэхэмжлэлийг төсөв хэтэрсэн гэх шалтгаанаар цахимд шивж нэхэмжлэл үүсэхгүй байгаа асуудлыг уламжлан шийдвэрлүүлж ажилласан. Энэ тухай мэдээллийг нэгдсэн эмнэлэг болон сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга нартай холбогдож мэдээлэл өгсөн. | 95 |
| 1.1.7 | “ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо -Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна. | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна. | 2025 онд 19 эмийн сан “Хөнгөлөлтэй эм худалдан авах” гэрээ байгуулсан бөгөөд ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна.<br>Эмийн сангуудаас асууж тодруулсан зүйлд тухай бүр хариулт өгч мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.<br>Гэрээ бүхий 19 эмийн санд 11320 тохиолдолд 305,1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1.2.1 | *Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.1.3, БГТ-1.4.3* Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | Хүргүүлсэн саналын тоо | Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 7 удаа санал хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | ЭМДҮЗ-ийн 03,04 дугаар тогтоолын төсөлд 2 санал, Нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулах санамж бичигт нэг санал тус тус хүргүүлсэн. | 90 |
| 1.2.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана. | - | Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2024 оны аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон 91 хүний судалгааг гарган өгч 24 иргэнийг шүүхийн байгууллагад шилжүүлэн ЭМДС-д төвлөрүүлсэн мөнгөн дүн-6,2 сая | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | Аймгийн прокурорын байгууллагатай хамтран ажиллаж Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1 дэх заалтад заасны дагуу гэм буруутай этгээдээс төлбөрийг гаргуулахаар Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2 иргэний өргөдөл гарган эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаанд нэхэмжлэгчээр оролцон 322000 төгрөгийн хохирлыг бүрэн барагдуулсан. Прокурорын газарт 2020,2021,2022,2023,2024 оны 194 иргэний лавлагаа, цагдаагийн газарт 8 иргэний лавлагаа мэдээлэл /нийт 28,5 сая төгрөг/ гарган 1698080 төгрөг нөхөн төлүүлж Эрүүл мэндийн даатгалын санд нөхөн төлүүлж хохирлыг барагдуулсан байна. | 100 |
| **Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | |
| Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 2.1.1 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1* Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг | | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 42.0 | 2025 онд 45 хувиас дээш хамруулна. | 2025 оны 04 сарын 30 ны байдлаар: Малчин 1951 хамруулахаас 1105 биелэлт-57% | 57 |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 100 | 2025 онд 100 хувиас дээш хамруулна. | Хамруулвал зохих 202, хамрагдсан 709, биелэлт 351%. | 351 |

<table>
<tr><td rowspan="2"></td><td rowspan="2">нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.</td><td rowspan="2"></td><td>Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь</td><td>2024 оны хамрагдалтын хувь 66</td><td>2025 онд 68 хувиас дээш хамруулна.</td><td>Хамруулвал зохих 658, хамруулсан 459, биелэлт 70%.</td><td>70</td></tr>
<tr><td>-Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь</td><td>2024 оны хамрагдалтын хувь 85</td><td>2025 онд 88 хувиас дээш хамруулна.</td><td>Ажил олгогчийн тоо-4964. Ажил олгогчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгчдийн мөнгөн дүнг авах боломжгүй байна.<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийн биелэлт 81 хувьтай байна.</td><td>81</td></tr>
<tr><td>2.1.2</td><td>Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.</td><td>-</td><td>Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо</td><td>2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээг гарган жилд 4 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн.</td><td>Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна.</td><td>2024 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавин Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/355 дугаар тушаалын дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган нэгтгэж Санхүү бүртгэлийн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.</td><td>100</td></tr>
<tr><td>2.1.3</td><td>ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,<br>Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.</td><td></td><td>Төвлөрүүлсэн мөнгөн дүн</td><td>2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 89 хувьтай.</td><td>ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 91-с доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна.</td><td>ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/12 тоот тушаалын дагуу аймгийн 15 сумдын засаг дарга нарт хамралтын төлөвлөгөө болон хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх үр дүнг тооцох албан бичгийг хүргүүлж ажиллалаа. Орлогын төлөвлөгөөний биелэлт 81%.
<table>
<tr><th>№</th><th>Даатгуулагчийн төрөл</th><th>Тоо</th><th>Биелэлтийн хувь</th></tr>
<tr><td>1</td><td>ААН. ХХЭ ажилгүй иргэд</td><td>459</td><td>70</td></tr>
<tr><td>2</td><td>Оюутан</td><td>709</td><td>351</td></tr>
<tr><td>3</td><td>Малчин</td><td>1105</td><td>57</td></tr>
<tr><td>4</td><td>Гадаадын иргэн</td><td>8</td><td>120</td></tr>
<tr><td>5</td><td>Нийт /биелэлт/</td><td>2281</td><td>81</td></tr>
</table></td><td>81</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.</td></tr>
<tr><td>2.2.1</td><td>БСТ 2.2.1, БГТ-2.2.1<br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах</td><td>ЭМДС</td><td>Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан</td><td>2024 онд 2,1 тэрбум төгрөгийн өглөгтэй тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.</td><td>Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна</td><td>Аймгийн хэмжээнд 38 эрүүл мэндийн байгууллагатай "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ" байгуулан гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналт хийж ажиллаж байна. 2025 оны 05 сарын 10 ны байдлаар 3 эрүүл мэндийн байгууллагаас 544,4 сая төгрөгийн , 19</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | | | | | эрүүл мэндийн байгууллагад 479,3 сая төгрөгийн өглөгтэй байна. Авлага нь нэгдсэн эмнэлэгт урьдчилгаа олгосон санхүүжилтээс шалтгаалж авлага үүсгэсэн байна. | |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна** | | | | | | | |
| Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 3.1.1 | *Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.1.2, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1*<br><br>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | | Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо<br><br>Гэрээний хэрэгжилтийн хувь | 2024 онд 39 гэрээт ЭМБ-ыг дүгнэсэн<br><br>2024 онд гэрээний хэрэгжилт 84,2 | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 86 хувиас доошгүй. | 2024 онд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ” байгуулсан 39 эрүүл мэндийн байгууллагаас “Абрай-Үр” эмийн сан холбогдох баримт бичгээ хугацаанд ирүүлээгүй ,гэрээ дүгнүүлээгүй тул гэрээг цуцалж 38 эрүүл мэндийн байгуулллагыг гэрээг ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/61 тоот тушаалын дагуу дүгнэн нэгтгэл дүгнэлтийг ХАГГ-т хүргүүлсэн. Дүгнэлт саналын дагуу 1 эмийн сангийн гэрээг түдгэлзүүлж 10 сумын эрүүл мэндийн байгууллагад Эрүүл мэндийн даатгалын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж гэрээг үргэлжлүүлэн байгуулж ажилласан.<br>Лавлагаа шатлалын гэрээний биелэлтийн дундаж 86,6%.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын гэрээний биелэлтийн дундаж 70,2%.<br>Эмийн сангийн гэрээний биелэлтийн дундаж 96,3%.<br>Дундаж хэрэгжилт-84,3 хувьтай байна. | 84,3 |
| 3.1.2 | 2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | ' | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо | Өрхийн ЭМТ-2, Сумын ЭМТ-15, Эмийн сан-18 | Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна. | 2024 онд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ” байгуулсан 39 эрүүл мэндийн байгууллагаас гэрээ дүгнүүлж хангалттай үнэлэгдсэн 38 эрүүл мэндийн байгууллага үүнээс эмийн сан-7, лавлага шатлал-3, анхан шатны эрүүл мэндийн төв-17 төв үргэлжлүүлэн гэрээ байгуулсан.<br>12 эм эргэлтийн сан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор татагдан буугдаж шинээр хувийн эмийн сан болж гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 3.1.3 | Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг | - | Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан | Лавлагаа шатлалын гэрээт 3, анхан шатны 17 эрүүл мэндийн | Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалыг гэрээ бүхий лавлагаа шатлалын-3, анхан шатны 16 эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд цахимаар танилцуулан оролцогчдын асуусан асуултад хариулан сар бүр нэхэмжлэлийн хяналтын зөрчил хасагдлын | 100 |

<table>
<tr><td></td><td>мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.</td><td></td><td></td><td>байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан.</td><td>хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.</td><td>шалтгаанаа хяналт дууссаны дараа цахимд хэрхэн шалгах, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтын мэдээллийг цаасаар хүргүүлж байхаар тохиролцон мэдээллийг сар бүр хүргүүлж ажиллаж байна.</td><td></td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.</td></tr>
<tr><td>3.2.1</td><td>БГТ 3.2.1<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.</td><td>ЭМДС</td><td>Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн,</td><td>Нийт 256 ЭМБ-ын 20629 түүвэрт нэхэмжлэлийн хяналт хийсэн байна.</td><td>Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.</td><td>Гэрээ бүхий 38 эрүүл мэндийн байгууллагуудаас гүйцэтгэлийн нэхэмжлэлийн сар бүрийн 05 ны дотор dua-invoice@emd.gov.mn хүлээн авч гүйцэтгэлд ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол болон ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/30 дугаар тушаалын дагуу нэхэмжлэлийн хяналт хийж гүйцэтгэж олгох санхүүжилтийн нэгтгэлийг 20 ны дотор Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлдэг. Гэрээ бүхий анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 8 төрлийн тусламж үйлчилгээнд нэхэмжлэлийн нарийвчилсан эмчийн хяналтаар 292 тохиолдлын зөрчил илрүүлж 32,7 сая төгрөгийн хасалтын хийсэн байна.
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">ЭМБ-ын нэр</th><th colspan="2">Нэхэмжилсэн</th><th colspan="2">Хасагдал</th></tr>
<tr><th>Хүн тоо</th><th>Мөнгөн дүн</th><th>Хүн тоо</th><th>Мөнгөн дүн</th></tr>
<tr><td>1</td><td>Улсын эмнэлэг</td><td>28953</td><td>3,411,328,047.00</td><td>268</td><td>101,947,851.00</td></tr>
<tr><td>2</td><td>ХХЭМБ</td><td>95</td><td>52,663,536.00</td><td></td><td>430,400.00</td></tr>
<tr><td>3</td><td>АШЭМБ</td><td>10000</td><td>950,061,916.00</td><td>292</td><td>32,777,220.00</td></tr>
<tr><td>4</td><td>Эмийн сан</td><td>11320</td><td>305,479,423.00</td><td>0</td><td>360,009.00</td></tr>
<tr><td>5</td><td>УСЭИҮ</td><td>677</td><td>121,220,000.00</td><td>0</td><td>950,000.00</td></tr>
<tr><td>6</td><td>ТХ эм</td><td>963</td><td>5,182,781.00</td><td>0</td><td>-</td></tr>
<tr><td>7</td><td>Нийт</td><td>52008</td><td>4,845,935,703.00</td><td>560</td><td>136,465,480.00</td></tr>
</table>
Тус хэлтсийн нийт албан хаагчдад 2025 оны эхний 4 сарын байдлаар нийт 83 эрүүл мэндийн байгууллагын 7909 түүвэр хуваарилагдсан бөгөөд түүвэрт нэхэмжлэлийн хяналт хийж 416 зөрчил илрүүлж 96,3 сая төгрөгийн хасагдал хийсэн байна.</td><td>100</td></tr>
</table>

| № | Албан хаагчдын нэрс | Хуваарилагдсан ЭМБ-ын тоо | Түүврийн тоо | Нэхэмжилсэн мөнгөн дүн | Хасагдал | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зөрчлийн тоо | Мөнгөн дүн |
| 1 | С.Долгорсүрэн | 30 | 2024 | 2189723025 | 60 | 46,346,135.00 |
| 2 | Д.Гансүрэн | 34 | 2764 | 335679949 | 265 | 36,197,511.00 |
| 3 | Ө.Түмэнжаргал | 19 | 3121 | 334613968 | 91 | 13,791,538.00 |
| 4 | **Нийт** | **83** | **7909** | **2860016942** | **416** | **96,335,184.00** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 | *БГТ 3.2.3*<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо | 2024 онд 20 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | Гэрээ бүхий 38 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан өдөр тутам утсаар болон биеэр хандсан эмч, мэргэжилтнүүдэд зөвлөн туслаж мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг.<br>Аймгийн төвийн анхан шатны 3 эрүүл мэндийн байгууллагад очин өдөр тутмын үйл ажиллагаатай танилцан программ хангамж системийн доголдол байгаа эсэх, төсвийн хуваарилалттай холбоотой тулгамдаж буй асуудлаар ярилцан санал солилцож асуусан асуултад хариулт өгсөн.<br>2025 оны 05 сарын 09 нд Нэгдсэн эмнэлэгийн удирдлагын багынхантай уулзаж үүссэн өрийн асуудал, цаашид анхаарах асуудал, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд ямар тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх боломжтой талаар мэдээлэл өгч санал солилцож ажилласан. Мөн нэгдсэн эмнэлэгийн амбулатори болон дэмжих төвийн өдөр тумын үйл ажиллагаатай танилцан эмч мэргэжилтнүүдийн сонирхсон асуултад хариулан иргэд даатгуулагчдаас тус эмнэлэгийн хүлээгдэл тусламж үйлчилгээний талаарх санал хүсэлтийг хүлээн авч ярилцаж эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчилж ажилласан. | 90 |
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч | - | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо<br>Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2024 онд нийт улсын байцаагчийн 12 эмб-д 12 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилт 80 хувь. | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | 2024 оны 05 сарын байдлаар 2024 оны 4 улирлын гүйцэтгэлд хийсэн нэхэмжлэлийн хяналтын зөрчлийн дагуу лавлагаа шатлалын 1 эрүүл мэндийн байгууллагад улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн ажилласанаар зөрчлийн тоо өмнөх мөн үеийн үзүүлэлтээс 73,4 хувиар буурч, мөнгөн дүн 86,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | | | | |  | |
| 3.2.4 | *БСТ 3.2.3, БГТ-3.2.2* Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | - | Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан | 2024 онд гэрээт 1 байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан. | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | 2025 оны 05 сарын байдлаар нэхэмжлэлийн хяналттай холбоотой иргэн даатгуулагчаас ирсэн гомдол санал байхгүй учир газар дээрх хяналт шалгалт хийгдээгүй байна. | 100 |
| **Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | |
| 4.1.1 | *ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3* Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан | Аймгийн ИТХ-д ОНХС-аас 20 сая төгрөг батлуулсан. | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | Аймгийн засаг даргад албан тоотоор ажлыг бүтээмжийг сайжруулах 3 үйлдэлт принтерийн хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн. | 100 |
| 4.1.2 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, | - | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-12 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, | Иргэд даатгуулагч аж ахуй нэгж байгуулагуудад "Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол", "Шинэчилсэн тоотоолын төслийн танилцуулга, иргэн даатгуулагчийн хариуцлага" сэдвээр 5 удаагийн танхимийн сургалт | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг,сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | | | | тайлагнасан байна. | зохион байгуулж давхардсан тоогоор 200 гаруй иргэн даатгуулагчдыг хамруулсан байна.<br>Хэлтсийн https://www.facebook.com/profile.php?id=100080497560994 пэйжээр агентлагийн пэйж дээрх мэдээллийн тухай бүр өөрийн пэйжид нийтлэн сурталчилж бусад салбарын болон аймгийн зарын группүүдэд шэйрлэн түгээж байна. Нийт 278 пост мэдээллийг нийтэлсэн байна. Үүнээс 25 постер мэдээллийг хос бичгээр нийтлэн олон нийтэд хүргэсэн байна. Сүүлийн 90 хоногийн мэдээ пост 11568 үзэлттэй байна. | |
| 4.1.3 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 2024 онд 650 иргэн, даатгуулагчдад мэдээ, мэдээллийг хүргэсэн. | 40-с доошгүй Иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. | 14 хоног тутам аймгийн засаг даргын тамгын газрын удирдлагын шуурхай хуралд хэлтсийн 14 хоногийн ажлын тайлан, цаг үеийн бусад ажлыг танилцуулан мэдээлэл өгч хэвшсэн.<br>Мэдээллийн самбарт гэрээ бүхий эрүүл мэндийн байгуулагуудад олгосон санхүүжилтийн мэдээллийг сар бүр байршуулан иргэд даатгуулагч аж ахуй нэгж байгуулагуудад "Шинэчилсэн тогтоолын төслийн танилцуулга, иргэд даатгуулагчийн хариуцлага" сэдвээр 5 удаагийн танхимийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 200 гаруй иргэн даатгуулагчдыг хамруулсан байна. | 90 |
| 4.1.4 | *БГТ 4.1.8*<br>Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 126 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Хэлтсийн фэйсбүүк пэйж болон гэрээт 39 эрүүл мэндийн байгууллагуудын фэйсбүүк групп чатаар сэтгэл ханамжийн судалгааны линк илгээн цахимаар мөн иргэд даатгуулагчдад тэнхимийн сургалт хийхдээ болон эрүүл мэндийн байгуулагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байхдаа гүүгл форумаар сэтгэл ханамжийн асуумжыг бөглүүлэн дүгнэлт хийж ажиллалаа.<br>ЭМДХ-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр нийт 78 иргэн даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэвэл:<br>Тус хэлтсийн үйл ажиллагаа, харьцаа хандлагыг нийт оролцогчдын 84,8 хувь нь эерэг сэтгэл ханамжтай, 12,2 хувь нь дунд 1,7 хувь нь мэдэхгүй, 1,3 хувь нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна. Иргэд даатгуулагчдад ЭМД-ын тухай мэдээ мэдээллиийг сайн түгээх сурталчлах, сургалтыг бүх хэлбэрээр зохион байгуулж хэрэгжилт үр дүнг тооцон ажиллах шаардлагатай байна. Хэрэгжилт 95 хувь. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.5 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | - | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 129, шийдвэрлэлт 100 хувь. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Ирсэн албан бичиг-66, явсан албан бичиг-84, ирсэн дотоод албан бичиг-21, явсан дотоод албан бичиг-12, шийдвэрлэлт-100 хувь.<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөө алдаатай, давхардуулж төлсөн гэх 14 иргэний өргөдлийг хүлээн авч ЭМДЕГ-т уламжлан илгээж бүрэн шийдвэрлүүлсэн. Шийдвэрлэлт 100 хувь.<br>Төр хариуцах иргэний ногдуулалт хийх 17, төрсөн хүүхдийн овог нэр бүртгэх 2, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл шалгуулах 104 иргэний хүсэлтийг хүлээн авч 100 хувь шийдвэрлэлээ. | 100 |
| 4.1.6 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж , биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана. | - | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн 17 удаа гаргаж хүргүүлсэн. Хэрэгжилт 100 хувь. | | Удирдлагын шуурхайн хуралдаанд тухай бүр бүрэн оролцож шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь бүрэн тайлагнасан. Нийт 16 удаагийн шуурхай хуралд оролцон 11 удаа шуурхайн хурлын биелэлт илгээсэн байна. | 100 |
| 4.1.7 | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, судалгааг хугацаанд нь үнэн зөвөөр гаргаж хүргүүлнэ | - | Үүрэг даалгавар, судалгааны тоо | ЭМДЕГ-ын газар хэлтсээс шаардсан цаг үеийн шинжтэй үүрэг даалгаварыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. | Удирдах дээд газраас өгөгдсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | ЭМДЕГ-ын газар хэлтсүүдээс ирүүлсэн цаг үеийн судалгаа мэдээллийг тухай бүр илгээж ажилладаг. Үүнд:<br>• Бодлого төлөвлөлтийн газарт шүдний тусламж үйлчилгээ үзүүлэдэг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын судалгаа-1,<br>• БТГ-т нэгдсэн эмнэлэгийн улаан бурхан өвчний тохиолдол бүрийн өртгийн судалгаа<br>• Худалдан авалт гэрээлэлтийн газарт- анхан болон лавлагаа шатлалын эрүүл эмндийн байгуулагуудын нэмэлт гэрээ, эмийн сангийн гэрээг баталгаажуулж хүргүүлэх-1<br>• Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн хуваарийг сарчлан тооцоолж хүргүүлэх<br>• ДАХШҮГ-т улсын үнэлгээний чадавхийн индексийн асуумжын судалгаа-1<br>• ДАХШҮГ-т 2024 оны гэрээт эрүүл мэндийн байгууллагын гэрээг дүгнэсэн тайлан мэдээ<br>• ТҮЧТХГ-т 2025 оны нэгдсэн эмнэлэгийн хэвийн болон ксеров хагалгааны төрлөгийн 84 өвчний түүхийн файлыг нэгтгэсэн тус тус тухайн газар хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.8 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ГТ-ний биелэлтийн хувь | Хэлтсийн мэргэжилтэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | 2 албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж Тамгын газарт хүргүүлсэн. Тамгын газрын 2025 оны 04/795 дотоод албан бичгийн дагуу хугацаанд нь дүгнэн дүнгийн нэгтгэл тайланг хүргүүлэх болно. | 100 |
| 4.1.9 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Архивын нэгжийн тоо (боть) | 2024 оны 15 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна. | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, журмын дагуу хэрэгжүүлж архивын 15 боть нэгж үүсгэн ЭМДЕГ-т хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. | 100 |
| 4.1.10 | Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | - | -Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо,<br>-Хэрэгжилтийн хувь | - | Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна. | Тус хэлтэс нь 2025 оны 04 сараас эхлэн хос бичгээр албан бичгээ хөтлөн илгээж хэвшсэн. | 100 |
| 4.1.11 | Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. | - | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо | - | Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн | Тус хэлтэс нь 2025 оны 04 сараас эхлэн албан бичгээ тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар илгээж хэвшсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна. | | |
| 4.1.12 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана | - | Хэрэгжилтийн хувь | Хуулийн хугацаанд ХАСХОМ, ХАСУМ-ээ 100 хувь мэдүүлсэн байна. | Хэрэгжилтийг ханган ажилласан байна. | ЭМДХ-ийн албан хаагчид ашиг сонирхолын зөрчлөөс ангид байж хуулийн хугацаанд ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн.<br>"АТГ-Олон нийтийн төв " пэйжаас мэдээлэл авахаас гадна авилгаас сэргийлж авилгын эсрэг нэгдэж энэхүү пэйжийн мэдээллийг бусдад шэйрлэн түгээж сурталчилан авилгаас ангид шударга хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| **5. Мэдлэг, чадвараа дээшлүүлэх зорилго** | | | | | | | |
| 5.1 | Эрүүл мэндийн даатгалын шинэчилсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь судалж , танилцан бүрэн мэдлэгтэй болно. | - | Шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх | Тогтоолын шинэчлэлтэй холбоотой сургалтад хамрагдсан | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | Хэлтсийн албан хаагчид агендтлагиас зохион байгуулсан тогтоолын төслийн талаарх 13 удаагийн сургалтад цахимаар бүрэн хамрагдсан. | 100 |
| 5.2 | ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | - | Хамрагдсан сургалтын тоо | - | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад бүрэн хамрагдсан байна. | Хэлтсийн албан хаагчид агендтлагиас зохион байгуулсан тогтоолын төслийн талаарх 13 удаагийн сургалт, мэдээллийн цаг хөтөлбөрт-6 удаа тус тус бүрэн хамрагдсан байна. | |
| 5.3 | Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ. | - | Хамрагдсан сургалтын тоо | Нийт 43 удаагийн сургалтад оролцсон. | Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна. | 2025 оны 04 дүгээр сарын 21-22 нд Өмнөговь аймгийн Даланзадгад суманд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан говийн бүсийн төрийн албан хаагчдад " Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" сэдэвт 2 өдрийн сургалтад хэлтсийн дарга С.Долгорсүрэн оролцсон бөгөөд сургалтын мэдээллийг хэлтсийн албан хаагчдад танилцуулж санал солилцсон.<br>"Төрийн албаны манлайлал" сэдэвт ЭМЯ-ы дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн сургалтад цахимаар бүрэн хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4 | Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах | - | Хамрагдсан сургалтын тоо | - | Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна. | Хэлтсийн албан хаагчид бие даан “Оюун түлхүүр” номыг өдөрт 2 сэдэв уншиж мэдлэгээ бататгаж байна. | 50 |
| 5.5 | *БГТ 4.1.4*<br><br>Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | - | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан. | Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | Хэлтсийн албан хаагчид агендтлагиас зохион байгуулсан тогтоолын төслийн талаарх 13 удаагийн сургалт, мэдээллийн цаг хөтөлбөрт-6, ЗДТГ-аас зохион байгуулсан сургалт-8, УИХ-ын гишүүдийн уулзалт хэлэлцүүлэгт-4 удаа тус тус хамрагдсан байна. | 100 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ............ /С.ЭНХБОЛД/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

Тэмдэг *(огноо)*
..........................

*Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА ............................ /Б:ОЮУНЦЭЦЭГ/
*(албан тушаал)*

*(гарын үсэг)*

*(огноо)*
2025.06.24 ..........................

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА ............ /С.ДОЛГОРСҮРЭН/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

Тэмдэг *(огноо)*
2025.05.20.